



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/61

Алтрага

Удирдамж батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, 25 дугаар зүйлийн 25.1.4, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын даргын 497 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Сумын нутаг дэвсгэр дээр газар өмчлөх, эзэмших, ашиглах болон сумын нийт бэлчээрийн газрын даац тогтоох, бэлчээрийн ачаалалд зохицуулалт хийх, хамгаалах, сайжруулах үйл ажиллагааг төлөвлөх зорилгын үүднээс аргачлалд заасан зарчмаар бэлчээр ашиглалтын хэсгүүдэд хувааж түүнд хамрагдах байнгын ашиглагч малчдын байршлыг бэлчээр ашиглалтын суурь зурагт тэмдэглэж ажилласугай.

2.Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний бэлтгэл ажлыг хангаж иргэн, Аж ахуйн нэгж, байгууллагаас санал авах ажлыг багийн ИНХ-ын дарга, Засаг дарга нартай хамтран 2024 оны 11 дүгээр сарын 01-ний дотор зохион байгуулахыг сумын Газрын даамал (Д.Батсайхан), багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Баттулга)-д даалгасугай.



ДАРГА

Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010140